

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ 2021 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хамрах хугацаа /2021.01.02 – 2021.12.15/

Улаанбаатар хот

<i>Хэрэгжүүлэх арга хэмжээ</i>	<i>Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг хэмжих шалгуур үзүүлэлт /тоо, хувь, чанар/</i>	<i>Тухайн жилийн хүрэх түвшин</i>	<i>Хариуцах нэгж, ажилтны нэр</i>	<i>Хугацаа /сар, улирал/</i>	<i>Биелэлт</i>
1	2	3	5	6	7
1.Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг үндэслэн төрийн жинхэнэ албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох саналыг холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх	Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн хэрэгжилт хангагдаж, төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдэнэ.	Жилд 1 удаа	Захиргаа, санхүүгийн хэлтэс Н.Золжаргал	II улиралд	Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйл, УИХ-ын 2019 оны 21 дүгээр тогтоолд заасан журмын дагуу байгууллагын 9 төрийн захиргааны албан хаагчид албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгуулах саналаа хүргүүлснээс, 1 албан хаагчид шинээр, 4 албан хаагчид зэрэг дэв, түүний нэмэгдлийг ахиулан олгох шийдвэр гарсан.
2.Байгууллагын албан хаагчдыг хөнгөлөлттэй нөхцлөөр орон сууцанд хамруулах үйл	Амьдрах нөхцөл сайжирч, нийгмийн асуудал шийдэгдэнэ.	Жилдээ	Захиргаа, санхүүгийн	III	Албан хаагчдаас судалгаа авч хөнгөлөлттэй орон сууц бариулах асуудлыг судалж байна. Цаг үеийн нөхцөл

ажиллагааг эхлүүлэх			хэлтэс	улиралд	байдлаас шалтгаалж ажил хойшлогдоод байна.
3.Албан хаагчдын ажлын үр дүн, гүйцэтгэлийг дүгнэн, улирал тутам урамшуулал олгох	Ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл бололцоог бүрэн хангаж, үйл ажиллагаа сайжирна.	Улирал тутам	Захиргаа, санхүүгийн хэлтэс	II, IV улиралд	Албан хаагчдын гүйцэтгэлийн тайлан, хөдөлмөрийн гэрээний биелэлтийг дүгнэсэн дүгнэлтийг үндэслэн, эхний хагас жилээр ТЗ-ны 11 албан хаагчийн цалингийн шатлалыг нэмэгдүүлэх, 42 албан хаагчид мөнгөн урамшуулал, жилийн эцсээр 61 албан хаагчид урамшуулал олгох тухай шийдвэрийг газрын даргын тушаалаар баталгаажуулав.
4.Хүүхдийн баяр, Шинэ жилийн баяраар албан хаагчдын 0-16 насны хүүхдүүдэд бэлэг гардуулах ажлыг зохион байгуулах	Ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл бололцоог бүрэн хангаж, хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэнэ.	Жилд 2 удаа	Захиргаа, санхүүгийн хэлтэс	II, IV улиралд	Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу Хүүхдийн баяраар албан хаагчдын 16 хүртэлх насны хүүхдийн судалгааг шинэчлэн гаргаж, нийт 72 хүүхдэд 2 304 000 төгрөгний баярын бэлэг өгөх үйл ажиллагааг газрын даргын А/128 дугаар тушаалаар, Шинэ жилийн баяраар нийт 64 албан хаагчийн гэр бүлд 3 200 000 төгрөгний бэлэг өгөх шийдвэрийг газрын даргын А/480 дугаар тушаалаар тус тус шийдвэрлүүллээ.

5.Байгууллагад ашиглагдаж байгаа компьютер, техник хэрэгслийн элэгдлийг тооцсоны үндсэн дээр шаардлагатай техник хэрэгслийг шинэчлэх арга хэмжээ авах	Ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл бололцоог бүрэн хангаж, хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэнэ.	Жилд 1 удаа	Захиргаа, санхүүгийн хэлтэс Н.Уранчимэг	II улиралд	Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу төсвийн хэмнэлттэй ажиллаж, 2 ш принтерийг 1 166 000 төгрөгөөр шинэчилсэн байна.
6.Үйлчилгээний ажилтнуудыг хөдөлмөрийн багаж хэрэгсэл, өвөл, зуны ажлын хувцсаар хангах	Ажлын байрны аюулгүй ажиллагаа хангагдана.	2 удаа	Захиргаа, санхүүгийн хэлтэс Н.Уранчимэг Д.Батбаяр	Жилдээ	Төв оффисын үйлчлэгчдийг ажлын хувцас, багаж хэрэгслээр хангасан. (2 үйлчлэгчийн хувцас-80 000 төгрөг)
7.Үйлчилгээний ажилчдад Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын сургалт зохион байгуулах	Ажлын байрны аюулгүй ажиллагаа хангагдана.	Жилд 1 удаа	ХАБ ажилтан	IV улиралд	Байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн С.Сэржаргал Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын газрын холбогдох хэлтэс рүү албан бичгээр хүсэлт гарган сургалтыг 12 дугаар сард зохион байгууллаа.
8.Албан хаагчийн ар гэрт гачигдал тохиолдох, хүндээр		Жилийн турш	Захиргаа, санхүүгийн	Жилийн турш	Тайлант хугацаанд ар гэрт нь гачигдал гарсан 8 албан хаагчид

өвдөх, урт хугацааны турш хөдөлмөрийн чадвараа түр алдсан тохиолдолд тусламж дэмжлэг үзүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх			хэлтэс		2 000 000 төгрөгийн тэтгэмж олгох газрын даргын шийдвэр гарсан байна.
9.Галлагаатай гэр байшинд амьдардаг ажилтан албан хаагчдын өвөлжилтийн бэлтгэлд зориулан сайжруулсан түлш худалдан авахад дэмжлэг үзүүлэх	Албан хаагчдын амьжиргаанд дэмжлэг болно.	Жилд 1 удаа	Захиргаа, санхүүгийн хэлтэс	IV улиралд	Галлагаатай гэр, байшинд амьдардаг албан хаагчдын судалгааг шинэчлэн гаргаж, 12 албан хаагчийн гэр бүлд өвөлжилтийн бэлтгэлд зориулан 3 600 000 төгрөгийн тусламж, дэмжлэг үзүүлсэн байна.
10. Ажлын байрны эрүүл ахуй, эрүүл мэндийн анхан шатны тусламжийн багаж хэрэгсэл, эм бэлдмэлээр тогтмол хангах	Ажиллах таатай нөхцөл бололцоо хангагдана.	Тогтмол	Захиргаа, санхүүгийн хэлтэс ХАБ ажилтан	Жилийн турш	Эмнэлэгийн булан нээж, Анхан шатны тусламж үзүүлэх, эм хэрэгсэл бэлдмэлээр ханган, албан хаагчдыг ковидын PCR шинжилгээг ажлын байранд 2 удаа, түргэвчилсэн тестийн шинэжилгээг сэжигтэй тохиолдолд байнга авч хэвшсэнээр бусад албан хаагчдыг эрсдлээс урьдчилан сэргийлж байна. Эм бэлдмэл, анхан шатны тусламжийн хэрэгсэл, ковид-19-өөс урьдчилан сэргийлэх эд материалд газрын даргын 3 удаагийн тушаалаар 9 636 100 төгрөгийн зардал гаргасан байна.

11.Ажил үүргээ идэвх зүтгэл, үр дүнтэй биелүүлж, өндөр амжилт гаргасан албан хаагчдыг шагнал урамшуулалд тодорхойлох	Албан хаагчдын ажиллах урам зориг, хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэнэ.	2 удаа	Захиргаа, санхүүгийн хэлтэс	I, IV дүгээр улиралд	НӨАУГ-ын 30 жилийн ойг угтан 56 албан хаагчийг төрийн одон медальд тодорхойлсноос 2 албан хаагч Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор, 2 албан хаагч Алтан гадас одонгоор, НИТХ-ын шагналаар 11, НЗД-ын шагналаар 8, НЗХ-ны шагналаар 10, НГБХЗХГ-ын шагналаар 4 албан хаагч тус тус шагнагдсан.
--	---	--------	-----------------------------	----------------------	---

Хянасан:

ЗСХ-ийн дарга

Б.Батбаяр

Тайлагнасан:

ЗСХ-ийн ахлах мэргэжилтэн

Н.Золжаргал

